



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyoцахим> хаяг эсхл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ УРЬДЧИЛСАН Г ҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	1
НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
1.2 Бүтээмж, бүтээмжийн өсөлт:	6
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	7
2.1. Нэгдсэн төсвийн орлого:	8
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:	10
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА	12
3.1. Гадаад худалдааны эргэлт:	12
3.2. Экспорт:	13
3.3. Импорт:	16
ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	17
4.1. Мөнгөний нийлүүлэлт:	17
4.2. Гадаад валютын албан нөөц:	19
4.3. Төлбөрийн тэнцэл:	19
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ.	19
5.1. Хүн ам, ажил эрхлэлт:	20
	20



МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тархалт намжиж, гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл сайжирснаар дотоодын нийт бүтээгдэхүүнийн өсөлт 2021 онд 1.4 хувьтай гарлаа.

Эдийн засаг 1.4 хувийн өсөлттэй гарлаа. ДНБ-ийн бодит өсөлт 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны 1 дүгээр улиралд огцом буурч -10.7 хувьтай байсан. Харин 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.4 хувийн өсөлттэй гарлаа.

Нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал буурчээ. 2,908.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,531.7 тэрбум төгрөгөөр, төлөвлөснөөс 1,092.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Төсвийн орлогын хувьд: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 12,689.4 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 3,225.5 тэрбум төгрөгөөр илүү бөгөөд тайлант орлогын төлөвлөгөө 486.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15,598.1 тэрбум төгрөгт хүрч 605.7 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 96.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1,693.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 16,095.8 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25.0 хувиар буюу 3,220.5 сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл 2,641.9 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) 27.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.6 их наяд буюу 14.8 хувиар өслөө. Үүнд, валютын харилцах 18.3 хувиар, төгрөгийн хадгаламж 11.9 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс өссөн. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 2.1 хувиар нэмэгдсэн бол өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар өссөн байна.

Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.8 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум ам.доллаароор буюу 2.7 дахин өссөн үзүүлэлт байна.


Үнэт цаасны арилжаа өсжээ. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр үнэт цаасны арилжаагаар 1.2 их наяд төгрөгийн гүйлгээ хийж, 691.5 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 1.1 их наяд төгрөгөөр, арилжсан үнэт цаас 338.3 сая ширхгээр тус тус өсжээ.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байна. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монголбанкны зарласан төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,848.9 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.58 төгрөгөөр чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 447.4 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 11.75 төгрөгөөр, өмнөх сараас 1.50 төгрөгөөр суларсан байна.

Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 938.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 331.3 тэрбум төгрөгөөр тус буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар буурчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хувьд 2.1 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 71.5 тэрбум төгрөг буюу 3.6 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.0 хувийг эзэлж байна.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**



НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:

ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 онд өмнөх оноос 4.6 хувиар буурсан бол 2021 онд урьдчилсан гүйцэтгэлээр 1.4 хувиар өссөн байна.

Зураг 1. ДНБ-ийн хэмжээ ба ДНБ-ийн бодит өсөлт /тэрбум төгрөг, хувиар/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр (2015 оны зэрэгцүүлэх үнээр) ДНБ 27.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.4 хувь буюу 0.4 их наяд төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. ДНБ-ийн өөрчлөлтийн салбарын оролцоо /нэгж хувиар/

	2018	2019	2020	2021
ДНБ-ийн өсөлт, бууралт, %	7.7	5.6	-4.6	1.4
Хөдөө аж ахуй	0.9	0.7	0.8	-0.8
Уул уурхай, олборлолт	0.9	-0.3	-1.4	0.2
Аж үйлдвэр, барилга	1.6	1.2	0.2	-1.0
Боловсруулах	1.4	0.3	0.3	0.0
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.2	0.1	0.0	0.2
Барилга	0.1	0.7	-0.1	-1.3
Үйлчилгээ	2.4	2.9	-3.0	1.8
Бөөний, жижиглэн худалдаа	0.0	1.2	-1.4	1.0
Тээвэр, мэдээлэл, холбоо	1.0	0.5	-0.9	-0.5
Үйлчилгээний бусад	1.4	1.3	-0.7	1.3
Бүтээгдэхүүний цэвэр татвар	2.0	1.0	-1.1	1.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДНБ, 2020 онд салбаруудын оролцоо 4.6 хувиар буурсны -1.4 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, -3.0 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлж байсан бол 2021 онд 1.4 хувиар өссөний 1.8 нэгж хувь нь үйлчилгээний салбарт, 1.3 нэгж хувь нь бүтээгдэхүүний цэвэр татварт ногдож байна.

Хүснэгт 2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар / тэрбум төгрөгөөр/

	2018	2019	2020	2021
ДНБ-ийн	32,582.6	37,839.2	37,883.0	44,090.8
Эцсийн хэрэглээ	23,019.1	26,627.5	28,570.0	28,762.4
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	18,883.4	21,667.6	22,648.6	22,490.4
Төрийн байгууллагын хэрэглээ	4,135.7	4,960.0	5,921.5	6,272.0
Хөрөнгийн нийт хуримтлал	12,830.4	13,467.7	8,383.4	15,541.6
Үндсэн хөрөнгийн хуримтлал	8,746.9	-2,256.0	8,830.8	11,412.3
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	4,083.4	2,879.0	-447.4	4,129.3
Цэвэр экспорт	-3,266.8	-2,256.0	929.6	-213.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.3. Бүтээмж, бүтээмжийн өсөлт:

Бүтээмжийг илэрхийлэх гол үзүүлэлт болох нэг ажиллагчид ногдох ДНБ /2015 оны зэрэгцүүлэх үнээр/ 2021 оны IV улиралд 6.2 сая төгрөг, жилийн дүнгээр 22.5 сая төгрөг болж, өмнөх оноос 935.8 мянган төгрөг буюу 4.3 хувиар өссөн байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 12.7 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 15.6 их наяд төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 3. Монгол Улсын нэгдсэн төсөв /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр		Өөрчлөлт	
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	12,202.6	12,689.4	486.8	4.0
Нийт зарлага цэвэр зээлийн дүн	16,203.8	15,598.1	-605.7	-3.7
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-4,001.2	-2,908.8	1,092.4	-27.3
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-8.8	-6.8	2.0	-22.7

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,908.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 1,531.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал төлөвлөсөн дүнгээс 1,092.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2.1 Нэгдсэн төсвийн орлого

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 12,689.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 34.1 хувь буюу 3,225.5 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 4.0 хувь буюу 486.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 5.3 хувь буюу 50.8 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 12.8 хувь буюу 306.5 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 2.9 хувь буюу 104.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 0.2 хувь буюу 18.6 тэрбум төгрөгөөр буурсан бол орон нутгийн төсвийн орлого 2.9 хувь буюу 104.1 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлого 12.8 хувь буюу 306.5 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 5.3 хувь буюу 50.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн орлогын 2021 оны урьдчилсан гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.
Нийт орлого ба тусламжийн дүн	10,767.0	10,639.1	3,573.8	3,677.9	2,398.7	2,705.2	951.3	1,002.0
Ирээдүйн өв сан	1,062.4	937.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сан	612.8	627.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	9,091.8	9,073.2	3,573.8	3,677.9	2,398.7	2,705.2	951.3	1,002.0
Татварын орлого	7,254.2	7,362.8	1,546.3	1,640.8	1,803.7	2,110.3	951.3	1,002.0
Татварын бус орлого	1,837.6	1,710.4	2,027.6	2,037.1	595.0	595.0	0.0	0.0


Эх сурвалж: Сангийн яам

Татварын орлого 8,504.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 0.8 хувь буюу 63.5 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 88.8 хувийг татварын орлого, 11.2 хувийг татварын бус орлого эзэлж байна. Татварын орлого 11,262.8 тэрбум төгрөг болсон ба төлөвлөгөө 5.4 хувь буюу 580.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын 29.5 хувийг орлогын албан татвар, 20.1 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.8 хувийг хөрөнгийн албан татвар, 25.2 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 7.3 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 8.4 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 7.7 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

Зураг 4. Татварын орлого /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 5.4 хувь буюу 580.0 тэрбум төгрөгөөр давж биелэхэд орлогын албан татвар 0.1 хувь, нийгмийн даатгалын орлого 20.0 хувь, хөрөнгийн албан татвар 13.3 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 1.2 хувиар, тусгай зориулалтын орлого 10.6 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 0.9 хувиар тус тус давж биелсэн нь нөлөөлжээ.


Төлөвлөгөөтэй харьцуулахад онцгой албан татвар 5.9 хувиар буюу 52.2 тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 9.4 хувиар буюу 89.7 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр татварын орлого 32.3 хувь буюу 2,751.2 тэрбум төгрөгөөр өсөхөд тусгай зориулалтын орлого 2.8 хувиар буурсан боловч орлогын албан татвар 48.9 хувиар, нийгмийн даатгалын орлого 42.4 хувь, хөрөнгийн албан татвар 28.9 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 28.4 хувь, онцгой албан татвар 6.4 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 27.3 хувь, бусад татвар, төлбөр, хураамж 7.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Татварын бус орлого 1,426.6 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 474.4 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 93.3 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар дутуу биелсэн байна.

Татварын бус орлогын 89.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 10.9 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 2.3 хувийг хувьцааны ногдол ашиг, 5.5 хувийг хүүгийн орлого, 8.5 хувийг торгуулийн орлого, 21.9 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.4 хувийг түрээсийн орлого, 15.6 хувийг газрын тосны орлого, 7.3 хувийг навигацгийн орлого эзэлсэн бол 36.1 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

Зураг 5. Татварын бус орлогын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Нийтлэг татварын бус орлогоос төсөвт байгууллагын өөрийн орлого 108.6 тэрбум төгрөг, хувьцааны ногдол ашиг 26.2 тэрбум төгрөг, газрын тосны орлого 15.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн ч, торгуулийн орлого 33.1 тэрбум төгрөгөөр, бусад орлого 12.8 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 3.5 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 1.5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл 16,203.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 96.3 хувийг зарлагдаж 605.7 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,693.9 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар өсөж 15,598.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Дээрх хугацаанд улсын төсвийн зарлага төлөвлөснөөс 436.8 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 381.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан бол нийгмийн даатгалын сангийн зарлага 42.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 126.6 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 1,396.3 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 344.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 81.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 774.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан байна.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үе	2021 оны урьдчилсан гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,904.3	16,203.8	15,598.1	96.3	-605.7
Нийт зарлага	13,863.2	16,765.1	15,801.4	94.3	-963.8
Урсгал зардал	10,828.9	13,460.5	12,754.4	94.8	-706.1
Бараа, ажил, үйлчилгээний зардал	4,851.2	4,955.6	4,660.1	94.0	-295.5
Хүү	939.2	971.5	827.7	85.2	-143.9
Татаас	375.1	501.0	453.7	90.6	-47.3
Урсгал шилжүүлэг	4,663.5	7,032.4	6,813.0	96.9	-219.4
Хөрөнгийн зардал	3,034.2	3,304.7	3,047.0	92.2	-257.7
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	41.1	-561.3	-203.3	36.2	358.1

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 12.2 хувь буюу 1,693.9 тэрбум төгрөгөөр өссөн ба үүнд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 244.4 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 17.8 хувь буюу 1,925.5 тэрбум, хөрөнгийн зардал 0.4 хувь буюу 12.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.9 хувь буюу 111.5 тэрбум төгрөгөөр буурч, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 14.8 хувь буюу 143.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 81.8 хувь буюу 12,754.4 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 53.4 хувийг урсгал шилжүүлэг, 36.5 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 6.5 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.6 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,925.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 191.1 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 111.5 тэрбум төгрөгөөр буурсан ч, татаас 78.6 тэрбум, урсгал шилжүүлэг 2,149.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

3.1. Гадаад худалдааны эргэлт:

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: Монгол Улс 2021 онд нийт 159 улстай худалдаа хийж гадаад худалдааны нийт бараа эргэлт 16,095.8 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25.0 хувь буюу 3,220.5 сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл 2,641.9 сая ам.долларын ашигтай гарсан байна..

Хүснэгт 6. Гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллар/

Үзүүлэлт	12 сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт /өмнөх оны мөн үеэс/	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	12,886.6	13,747.1			3,220.5	25.0
-Экспорт	7,011.8	7,619.6	7,576.3	9,247.1	1,670.8	22.1
-Импорт	5,874.8	6,127.5	5,298.9	6,848.6	1,549.7	29.2
Тэнцэл	1,137.0	1,492.1	2,277.4	2,398.5	121.1	5.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл 2,398.5 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 121.1 сая ам.доллар буюу 5.3 хувиар өсөхөд импорт 1,549.7 сая ам.доллар, экспорт 1,670.8 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл БНХАУ-тай 2021 онд 10.1 тэрбум ам.долларын, ОХУ-тай 2.1 тэрбум ам.долларын худалдааг хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар, БНХАУ-тай хийсэн худалдаа 37.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллар/

Улс	Төрөл	Жил бүрийн 4-р улирал (өссөн дүнгээр)			Өөрчлөлт (+, -)	
		2019	2020	2021	2021.12/2020.12	
					Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	8,850.5	7,403.9	10,163.9	2,760.0	37.2
	Экспорт	6,789.7	5,493.6	7,643.9	2,150.3	39.1
	Импорт	2,060.8	1,910.3	2,520.0	609.7	31.9
	Тэнцэл	4,728.9	3,583.3	5,123.9	1,540.6	43.0
ОХУ	Нийт эргэлт	1,798.0	1,457.3	2,073.4	616.1	42.3
	Экспорт	68.1	57.3	112.8	55.5	96.8
	Импорт	1,729.9	1,400.0	1,960.6	560.6	40.0
	Тэнцэл	-1,661.8	-1,342.7	-1,847.8	-505.1	37.6
Бусад	Нийт эргэлт	3,098.6	4,014.0	3,858.4	-155.6	-3.9%
	Экспорт	761.8	2,025.4	1,490.4	-535.0	-26.4%
	Импорт	2,336.8	1,988.6	2,368.0	379.4	19.1%
	Тэнцэл	-1,575.0	36.8	-877.6	-914.4	-2,484.8%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын гадаад худалдаа нь ОХУ болон бусад орнуудтай алдагдалтай, БНХАУ-тай ашигтай гарсан байна.

3.2. Экспорт:

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9,247.1 сая ам.долларт хүрч, эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үетэй харьцуулахад 1,627.5 сая ам.доллар буюу 21.4 хувиар, харин 2020 оны мөн үетэй харьцуулахад 1,670.8 сая ам.доллар буюу 22.1 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 7,516.0 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 2,259.9 сая ам.доллар буюу 43.0 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1,731.2 сая ам.доллар болж, өмнөх оноос 589.1 сая ам.доллар буюу 25.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт /сая ам.доллар/

Үзүүлэлт	12 сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	6,070.3	6,377.6	5,256.0	7,516.0	2,259.9	43.0	81.3
Эрдсийн бус бусад бүтээгдэхүүний экспорт	941.4	1,242.0	2,320.3	1,731.2	-589.1	-25.4	18.7
Нийт экспорт	7,011.8	7,619.6	7,576.3	9,247.1	1,670.8	22.1	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 9. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	12 сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	1,436.7	1,403.6	1,395.1	1,282.5	-112.5	-8.07
Нүүрс	сая.тн	35.8	36.5	28.6	15.7	-12.9	-45.1
Төмрийн хүдэр	сая.тн	7.4	8.4	8.2	7.1	-1.1	-13.4
Цайрын баяжмал	мян.тн	123.9	134.8	134.1	112.6	-21.4	-16.0
Алт	тн	3.4	9.1	30.5	17.2	-13.2	-43.4
Боловсруулаагүй нефть	сая. баррель	6.2	6.5	4.1	4.3	0.3	6.8
Катодын зэс	тн	12.9	11.9	9.6	9.8	0.2	2.1
Жоншны баяжмал	мян.тн	555.2	700.1	678.9	644.7	-34.2	-5.0
Адууны мах	мян.тн	32.2	30.8	17.6	7.0	-10.5	-60.0
Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	79.5	68.6	23.4	7.6	-15.8	-67.6
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.3	592.8	344.0	441.4	97.4	28.3
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	116.2	54.0	49.2	66.3	17.1	34.7
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	145.5	121.0	85.2	77.0	-8.2	-9.6
Самнасан ноолуур	тн	630.2	507.2	260.0	424.0	164.0	63.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 10. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого /сая ам.доллар/

Барааны төрөл	12 сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	2,012.2	1,795.9	1,778.0	2,899.9	1,121.9	63.1
Нүүрс	2,786.2	3,074.4	2,123.7	2,763.9	640.3	30.1
Төмрийн хүдэр	342.2	576.4	640.0	952.2	312.2	48.8
Цайрын баяжмал	197.8	189.0	167.7	176.4	8.7	5.2
Алт	144.5	418.4	1,787.7	1,004.5	-783.1	-43.8
Боловсруулаагүй нефть	392.0	3.8	150.9	273.4	122.5	81.2
Катодын зэс	82.4	68.9	59.3	88.5	29.2	49.3
Жоншны баяжмал	189.9	205.5	156.3	144.1	-12.2	-7.8
Адууны мах	65.0	57.7	33.0	14.4	-18.5	-55.9
Өлөн гэдэс	8.6	8.5	8.9	15.3	6.4	71.1
Үхэр, адууны боловсруулсан шир	8.4	6.4	2.3	0.8	-1.4	-62.8
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.01	1.8	0.5	0.7	0.2	50.1
Хонь, хурганы боловсруулсан арьс	3.1	1.2	1.0	1.3	0.3	31.8
Ямаа, ишигний боловсруулсан арьс	5.0	4.0	3.1	2.4	-0.7	-22.0
Самнасан ноолуур	54.9	45.3	16.9	39.9	23.0	136.6
Бохир ноолуур	252.0	283.3	185.3	253.6	68.3	36.9
Хонины самнаагүй ноос	20.2	20.4	9.0	5.4	-3.4	-37.6
Нийт экспортод эзлэх хувь	93.6%	88.7%	94.0%	93.4%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нийт экспортын 31.4 хувийг зэсийн баяжмал, 29.9 хувийг нүүрс, 10.3 хувийг төмрийн хүдэр, 10.9 хувийг боловсруулаагүй алт, 3.0 хувийг боловсруулаагүй нефть, 1.9 хувийг цайрын хүдэр, 1.6 хувийг жоншны хүдэр эзэлсэн байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 7,516.0 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 2,259.9 сая ам.доллар буюу 43.0 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1,731.2 сая ам.доллар болж, өмнөх оноос 589.1 сая ам.доллар буюу 25.4 хувиар буурсан байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 2,259.9 сая ам.доллар буюу 43.0 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1.Нүүрс: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15.7 сая тонн нүүрс экспортолж, 2,763.9 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 12.9 сая тонноор буурсан боловч экспортын орлого 640.3 сая ам.доллараар буюу 30.1 хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 101.8 ам.доллар буюу 137.1 хувиар нэмэгдсэн нь нүүрсний экспортын орлого өсөхөд нөлөөлжээ.

2.Зэсийн баяжмал: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 63.1 хувь буюу 1,121.9 сая ам.доллараар нэмэгдэж, 2,899.9 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 1,282.5 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.1 хувь буюу 112.5 мянган тонноор буурсан ба экспортын дундаж үнэ нь 77.4 хувиар өссөн байна.

3.Төмрийн хүдэр: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 7.1 сая тонн болж, 952.2 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 48.8 хувь буюу 312.2 сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 13.4 хувь буюу 1.1 сая тонноор буурсан боловч 1 тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 71.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

4.Цайрын баяжмал: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 112.6 мянган тонн болж, 176.4 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 5.2 хувь буюу 8.7 сая ам.доллараар өсөхөд цайрын баяжмалын биет хэмжээ 16.0 хувь буюу 21.4 мянган тонноор буурсан боловч 1 тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 25.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

5.Боловсруулаагүй нефть: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр боловсруулаагүй нефтийн экспортын тоо хэмжээ 4.3 сая баррельд хүрч, 273.4 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Боловсруулаагүй нефтийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 81.2 хувь буюу 122.5 сая ам.доллараар өсөхөд биет хэмжээ эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үеэс 2.2 сая баррель буюу 33.6 хувиар буурсан боловч өмнөх оны мөн үеэс 6.8 хувь буюу 0.3 сая баррелиар өссөн, мөн тайлант хугацаанд 1 тонн түүхий газрын тосны экспортын дундаж үнэ 72.8 хувиар нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна.

6.Катодын зэс буюу тунгаасан зэс ба хайлш: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр катодын зэсийн экспортын тоо хэмжээ 9.8 тоннд хүрч, 88.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Катодын зэсийн экспортын орлого 2019 оны мөн үеэс 28.5 хувь буюу 19.6 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 49.3 хувь буюу 29.2 сая ам.доллараар өссөн нь катодын зэсийн биет хэмжээ 2.1 хувь буюу 0.2 тонноор өссөн, 1 тонн тунгаасан зэсийн экспортын дундаж үнэ 46.2 хувиар нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна.

3.3. Импорт

Нийт импортын 19.5 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 80.5 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт 1,338.6 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 331.3 сая ам.доллараар буюу 32.9 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 5,510.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1,218.4 сая ам.доллар буюу 28.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 11. Эрдсийн бүтээгдэхүүний импорт /сая ам.доллар/

	12 сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	1,325.8	1,372.3	1,007.2	1,338.6	331.3	32.9	19.5
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	4,549.0	4,755.2	4,291.7	5,510.1	1,218.4	28.4	80.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 19.5 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 18.2 хувь, автотээвэр, агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги 17.9 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 14.1 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 8.6 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 8.3 хувийг тус тус эзэлж байна.

ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**4.1. Мөнгөний нийлүүлэлт:**

Мөнгөний нийлүүлэлт 2021 оны жилийн эцсийн байдлаар 27.8 их наяд төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3.6 их наяд төгрөг буюу 14.8 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 21.3 их наяд төгрөг болж 1.3 их наяд буюу 6.5 хувиар өссөн нь нөлөөлжээ. Валютын харилцах 23.2 тэрбум төгрөгөөр буюу 18.4 хувиар буурсан бол төгрөгийн хадгаламж 176.2 тэрбум төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 12. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	(12 сарын гүйцэтгэл)			Өөрчлөлт (+/-) 2021/2020	
	2019	2020	2021	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	20,833.8	24,220.0	27,798.6	3,578.6	14.8
Бараг мөнгө	16,929.6	20,022.6	21,314.3	1,291.7	6.4
-Төгрөгийн хадгаламж	11,119.7	13,398.3	14,996.6	1,598.3	11.9
- Валютын хадгаламж	3,483.7	4,641.7	3,973.1	-668.6	-14.4
- Валютын харилцах	2,326.2	1,982.6	2,344.5	361.9	18.2
M1 мөнгө	3,904.2	4,197.4	6,484.3	2,286.9	54.4
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	897.4	991.5	1,105.6	114.1	11.5

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 13. Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн эцсийн байдал			Өөрчлөлт (+/-) 2020/2021	
	2019	2020	2021	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	18,096.1	17,206.9	20,876.4	3,669.5	21.3
- Хэвийн зээл	15,447.0	13,927.9	17,857.2	3,929.3	28.2
- Хугацаа хэтэрсэн зээл	824.0	1,269.4	938.1	-331.3	-26.1
- Чанаргүй зээл	1,825.1	2,009.6	2,081.1	71.5	3.6
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	10.1	11.7	10.0	-1.7	-14.6
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	4.5	7.4	4.5	-2.9	-39.2

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 20.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 618.0 тэрбум төгрөг буюу 3.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.7 их наяд төгрөг буюу 21.3 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 50.8 хувь нь иргэдийнх байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 938.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 331.3 тэрбум төгрөг буюу 26.1 хувиар буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2.1 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 71.5 тэрбум төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар буурчээ.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 их наяд төгрөгийн гүйлгээ хийж, 691.5 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 1.1 их наяд төгрөгөөр, арилжсан үнэт цаас 338 сая ширхэгээр тус тус өсжээ.


Үнэт цаасны гүйлгээ 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31.8 тэрбум төгрөг болжээ. Арилжсан үнэт цаас 12.5 сая ширхэг болж, өмнөх сараас 125.5 сая ширхэгээр буурчээ.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 41668.8 нэгж болж өмнөх оны мөн үеэс 23542.7 нэгжээр өссөн байна.

Валютын ханш: 2021 оны жилийн эцсийн байдлаар Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,848.9 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.6 төгрөгөөр чангарсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 447.4 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 11.8 төгрөгөөр суларсан байна.

Зураг 6. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юаны дундаж ханш


АНУ-ын доллар ба БНХАУ-ын юаны дундаж ханш, төгрөгөөр,



Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 13.4 хувь байна.

Зураг 7. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2021 оны жилийн эцсийн байдлаар 20,808.6 тонн болж, 2019 оны мөн үеэс 5,602.10 тонноор өссөн байна.


Зураг 8. Алтны хэмжээ /кг/



Эх сурвалж: Монголбанк

4.2. Гадаад валютын албан нөөц:

Зураг 9. Гадаад валютын албан нөөц, (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

4.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.8 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оноос 1.2 тэрбум ам.доллороор өссөн байна. Уг өсөлтөд анхдагч орлогын алдагдал өмнөх оноос 823.6 сая ам.доллороор өсөж, 2.1 тэрбум ам.доллар болсон нь голлон нөлөөлжээ. Харин урсгал данс 2021 оны 12 дугаар сард 722.8 сая ам.долларын алдагдалтай гарчээ.

Хүснэгт 14. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд

	2020		2021*	
	XII	I-XII	XII	I-XII
Урсгал данс	- 84.9	- 674.6	- 722.8	-1,824.7
Хөрөнгийн данс	8.8	102.8	10.1	126.1
Санхүүгийн данс	- 801.0	-1,504.2	- 877.5	-1,746.7
Алдаа болон орхигдуулга	52.8	- 145.6	49.9	- 269.7
Нөөц хөрөнгө	-777.6	786.9	214.8	- 221.6

Эх сурвалж: Монголбанк

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Ажилгүйдэл:

Ажиллах хүчний 1.1 сая буюу 91.9 хувь нь ажиллагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.5 мянгаар өссөн байна.

Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын 878.2 мянга буюу 41.7 хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын 45.1 мянга буюу 29.8 хувь нь боломжит ажиллах хүч, 99.4 мянга буюу 65.7 хувь нь ажилгүй хүн байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалт өмнөх оны мөн үеэс 15.1 мянгаар буюу 9.1 хувиар, өмнөх улирлаас 2.1 мянган хүнээр буурсан байна.

Улсын хэмжээнд ажилгүй хүн 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 99.4 мянга байгаагийн 56.1 мянга нь эрэгтэйчүүд, 43.3 мянга нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 7.3 мянгаар буюу 7.9 хувиар, өмнөх улирлаас 2.1 мянгаар буюу 1.4 хувиар өссөн байна. Ажилгүй хүний тоо өмнөх оны мөн үеэс 30-34 насны бүлэгт 5.9 мянгаар, өмнөх улирлаас 30-34 насны бүлэгт 5.3 мянгаар, 40-49 насны бүлэгт 5.9 мянгаар тус тус өсжээ.

Ажиллах хүчний оролцооны түвшин 58.3 хувь болж, үүнээс эрэгтэйчүүдийнх 65.6 хувь, эмэгтэйчүүдийнх 51.9 хувь байна. Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар өссөн байна. Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 8.1 хувь байгаа бөгөөд үүнийг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийнх 8.7 хувь, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 7.4 хувь байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

